



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ХУШААТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 11

Энхтэл

Сумын Бэлчээр ашиглах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн 2 дах заалт, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 сарын 04-ны өдрийн 39 дүгээр тогтоол /Төрөөс малчдын талаар баримтлах бодлого/Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолуудыг /Монгол мал хөтөлбөр / үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Сумын бэлчээр ашиглах журмыг хавсралтаар баталсугай.

2.Сумын Бэлчээр ашиглах журмыг иргэдэд сурталчилан таниулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид, Газрын даамал, Байгаль Орчины алба, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Сумын бэлчээр ашиглалтын хуваарийг жил тутам шинэчлэн гаргаж тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллахыг Сумын Засаг дарга /Г.Галбадрах/-д үүрэг болгосугай.

4. ХАА-н тасгийн дарга / Т.Баасандорж/-д даалгах нь:

4.1 Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах сангийн журам боловсруулан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2013 онд багтаан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.2 Энэхүү журмын хэрэгжилтийг жил бүрийн эцэст Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж байх.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

Нэг: Журмын үндсэн нөхцөл шаардлага .

- 1.1 Сумын нутаг дэвсгэр МУ-ын Газрын тухай хууль , Тариалангийн тухай хууль, Холбогдох бусад эрх зүйн баримт бичиг энэхүү журмыг мөрдлөгө болгоно.
- 1.2 Сумын бэлчээр ашиглалтын өрөнхий хуваарийг жил тутам шинэчлэн гаргаж ГЗБ-ын төлөвлөгөөнд тусган ИТХ-р хэлэлцүүлэн баталж мөрдөнө.
- 1.3 Хаваржаа зусланд гарахдаа үр тариа, төмс хүнсний ногоо , хадлангийн талбайг жил бүрийн 5 сарын 01-наас өмнө чөлөөлөх, 10-р сарын 20 наас хойш өвөлжөө намаржаандаа буухыг журмын дагуу зохион байгуулна.
- 1.4 Малчид өөрсдийн эзэмшлийн өвөлжөө хаваржаандаа бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, хаших талаар санаачлагатай ажиллаж , зун намарт бэлчээрээ сэлгэж өвөлжөө хаваржааны бэлчээрийг чөлөөлнө.
- 1.5 Бэлчээрийн даац хүрэлцэхгүй болсон, ган зудын гамшиг тохиолдсон зэргээс шалтгаалж өөр аймаг сумын нутагт отор нүүдэл хийхээр бол 8,9-р сард багтаж сумын Засаг дарга холбогдох аймаг сумын удирдлагатай тохиролцон гэрээ байгуулж отор нүүдлийг зохион байгуулна.
- 1.6 Өвөлжөөний газрыг газрын даамалаар байршлыг газар дээр нь заалгаж , хэмжүүлж, эзэмших шийдвэр гарсаны дараа өвөлжөөг барих бөгөөд тариалангийн талбайн захаас 200 м-с дотогш өвөлжөө барихыг хориглоно.
- 1.7 Сумын төвийн орчмын бэлчээр нь сумын төвөөс 3 км дотор байх бөгөөд 100 –с дээш богтой , 15 –с дээш бодтой малтай өрх энэ бэлчээрийг ашиглахгүй
- 1.8 Сумын төвийн малчдыг зунд зусланд гарах
- 1.9 Журмын 1.2, 1.3, 1.4, 1.6, 1.7 дэхь заалтыг зөрчсөн орон нутгийн малчдад захиргааны хариуцлага тооцно

Хоёр: Журмын үндсэн чиглэл

- 2.1. Сумын нийт бэлчээрийн даацыг өөрийн сумын мал өвөлжих хаваржихад бүрэн хүрэлцээтэй , нэмэгдэл ачаалал авах бололцоотой гэж үзсэн нөхцөлд гадны аймаг сумын зохих тооны малыг отроор өвөлжүүлж хаваржуулж болно.
- 2.2 . Гадны аймаг сумын малчдыг отроор өвөлжүүлж хаваржуулах гэрээг сумын Засаг дарга, холбогдох сумдын удирдлагатай тохиролцон ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээрийн зориулалтын газарт нутагшуулахаар гэрээ байгуулна.

Үүнд: -Отроор өвөлжих хаваржих өрхийн тоо, ам бүл , өвөлжих малын тоо

- Оторлох хугацаа
- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга туулгалтанд хамрагдсан албан бичиг тодорхолт
- Отрын ахлагчийг томилсон тухай шийдвэр албан бичгийн хамт ирүүлнэ.

- 2.3 Дээрхи гэрээ албан тоотыг үндэслэн сумын засаг дарга отроор нутаглах зөвшөөрлийн бичиг олгоно.

2.4 Отроор өвөлжиж хаваржиж байгаа малчид бэлчээр уст цэгийг зүй зохистой ашиглах, байгаль бохирдуулахгүй, гал түймэр гаргахгүй байх, нийгмийн дэг журмыг сахих

2.5 Отрын нутагт отроор өвөлжиж хаваржсан талаар 2 талын уулзалт гэрээ хийж дүгнэх

Гурав: Хориглох зүйл

3.1 Өвөлжих, хаваржих, зусах, намаржих зөвшөөрөл аваагүй малчдыг сумын нутагт оруулахгүй байх, зөвшөөрөлтэй нөхцөлд зааж өгсөн нутгаас өөр газарт дур мэдэн буух, худаг уст цэг болон байгаль орчныг бохирдуулах бэлчээрийг зүй зохисгүй ашиглахыг хориглоно.

3.2 Орон нутгийн малчид хажуудаа зөвшөөрөлгүй отрын айл буулгах, мал оруулахыг хориглоно.

3.3 Сумын нутаг дэвсгэрт малаа байлгах зөвшөөрөлгүй бэлчээр ашигласны хураамж төлсөн нь тухайн бэлчээрийг ашиглах үндэслэл болохгүй

3.4 Гэрээ байгуулаагүй мөн мал эмнэлэг ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээгүй мал бүхий айл өрхийг орон нутгийн бэлчээрт оруулахыг хориглоно.

Дөрөв: Төлбөр хураамж

4.1 Орон нутагт гэрээний дагуу ирж малаа оторлох өрх бүрээс бэлчээр ашигласны хураамжийг хонин толгойд шилжүүлэн адуу -6.0, үхэр 6.0, тэмээ 5.0, ямаа 1.5, хонь 1.0 гэсэн итгэлцүүрээр тус тус тооцож авна.

4.2 Тухайн сумын МЗУ-ийн нэгжээс олгосон, мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээг үндэслэн оторлох мал сүргийг нутаглуулах бэлчээр ашиглах худаг уст цэгийн зөвшөөрлийг 90 хоног хүртэл хугацаагаар сумын Засаг дарга олгоно.

4.3 Бэлчээр ашигласны төлбөр хураамжийг байглийн ургамал ашигласны, Газрын төлбөрийн тухай хуулиудын зохих заалтад нийцүүлэн бодыг хонин толгойд шилжүүлэн 3 сарын дотор хураан авна.

Бэлчээр ашигласны хураамж

Хураажмийн төрөл	Зөвшөөрөлтэй эсэх	Тогтоох үнэ, хоногт	
1 Бэлчээрийн хураамж	Гадны малчид, мал бүхий иргэд зөвшөөрөлтэй /1 хонин толгойд /	250 төгрөг	90 хоног хүртэл
2 Бэлчээрийн хураамж	Гадны малчид, мал бүхий иргэд зөвшөөрөлгүй / 1 хонин толгойд/ болон өөрийн малчдын зөрчил гаргасан малчдаас 1.3, 1.4 дахь зөрчсөн	40 төгрөг	1 хоногт

Жич: Нэг хонины идэх өвс 1.6 кг / нэг боодол өвс 20кг бөгөөд 1000 төгрөг / 1кг өвс $50 \times 1.6 = 80$ төгрөг үүний 50% буюу 40 төгрөгийн хураамж авна.

4.4 Зун намрын улиралд мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаагүй, мал бүхий айл өрхийг орон нутагт оруулахыг

хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд 10000-50000 төгрөгөөр бодож хураамж ноогдуулна. / Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 14.1.7 дахь заалт

4.5 Хураамжийг сумын " Мал сүргийг байглийн гамшиг зуднаас хамгаалах сан"-г байгуулж төвлөрүүлнэ. Санд төвлөрүүлсэн хураамжийг бэлчээр сэргээх , олон наст ургамлын үр тарих, өвс тэжээл худалдан авч нөөц буй болгох, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх , журмын хэргэжилтийг хангахад зарцуулна.

Тав: Хариуцлага

5.1 МУ-ын Захиргааны хариуцлагын тухай хууль, Газрын тухай хууль, Байглийн ургамлын тухай хууль, Бэлчээр ашиглалтын журмыг зөрчиж дур мэдэн бэлчээр , хадлангийн газар ашигласан аймаг сумын малчдыг холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.2 Өөр аймаг сумаас ирсэн малчдыг өвөлжөө хаваржаандаа зуслан намаржаандаа зөвшөөрөлгүй буулгасан сумын иргэд малчин мал бүхий иргэд төлбөр хураамж төлөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа: Журмын хэрэгжилтэнд хяналт тавих

6.1 Бэлчээр ашиглалтын журмыг хэрэгжилтэнд Сум, багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэсэг, ХАА-н тасгийн мэргэжилтнүүд, БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавин ажиллана.